



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Улсын геологийн зургийн редакцын
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А-306 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын геологийн зургийн редакцын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжиж ажиллахыг Төрийн захиргааны дарга /Шинэ-Од/-д даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан албаны даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн "Улсын геологийн зургийн редакцын зөвлөл байгуулах тухай" А/32 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.МӨНХТӨР

182401 00089

Үндэсний геологийн албан
даргын
2024 оны 4 дугаар сарын 25-ны
өдрийн 4 дугаар тушаалын 1
дүгээр хавсралт

УЛСЫН ГЕОЛОГИЙН ЗУРГИЙН РЕДАКЦИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэр		Гишүүд	Зэрэг цол	
1	Ерөнхий редактор		Г.Дэжидмаа	Доктор (Ph.D)	
2	Нарийн бичгийн дарга		Ц.Минжинсор	Зөвлөх ГМС	
3	Геологи	Зөвлөх	Ж.Бямба	Доктор (Sc.D)	
4			Д.Чулуун	Доктор (Ph.D)	
5			О.Гэрэл	Доктор (Sc.D)	
6			Д.Доржнамжаа	Доктор (Sc.D)	
7			Д.Оролмаа	Доктор (Ph.D)	
8			Гишүүд	Х.Уламбадрах	Доктор (Ph.D)
9		О.Мөнхцэцэг		Доктор (Ph.D)	
10		Т.Оюунчимэг		Доктор (Ph.D)	
11		Б.Ганбат		Доктор (Ph.D)	
12		Ашигт малтмал		Зөвлөх	Г.Ухнаа
13			Гишүүн	Ж.Эрдэнэбаяр	Доктор (Ph.D)
14	Гидрогеологи	Зөвлөх	Н.Буянхишиг	Доктор (Ph.D), дэд профессор	
15		Гишүүн	Д.Энхбаяр	Доктор (Ph.D)	
16	Геоморфологи	Зөвлөх	Б.Бат	Доктор (Ph.D)	
17	Геохими	Зөвлөх	А.Готовсүрэн	Доктор (Ph.D)	
18		Гишүүн	Х.Шаует	Магистр (MSc)	
19		Гишүүн	Ө.Дугарнаваг	Бакалавр	
20	Геофизик	Зөвлөх	Ц.Баатарчулуун	Доктор (Ph.D)	
21		Гишүүн	Д.Отгонбаяр	Мэргэшсэн инженер	
22		Гишүүн	Б.Сайнжаргал	Магистр (MSc)	
23	Геоэкологи	Зөвлөх	Б.Наранчимэг	Доктор (Ph.D)	
24		Гишүүн	Л.Шинэцэцэг	Магистр (MSc)	
25	Инженер геологи	Гишүүн	Я.Болормаа	Магистр (MSc)	
26	Тандан судалгаа	Зөвлөх	А.Баясгалан	Доктор (Ph.D)	
27		Гишүүн	А.Баттүшиг	Магистр (MSc)	
28	Зургийн техникийн асуудал	Гишүүн	Ш.Алтаншагай	Магистр (MSc)	

Үндэсний геологийн албан даргын
2024 оны 8 дугаар сарын 25-ны
өдрийн 7/3 дугаар тушаалын 2
дугаар хавсралт

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр зохиогдсон геологийн төрөл бүрийн зураг (1:200 000-ны масштабтай геологийн зургийн нэгтгэлд төвлөрнө), тайлбар бичигт хяналт тавих, төсөл хэрэгжүүлэгчид зургийн нэгтгэл, геологийн хил заагийн маргааныг шийдвэрлэхэд зөвлөмж өгөх үүрэг бүхий орон тооны бус Редакцын зөвлөлийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Үйл ажиллагааны чиглэл, бүрэлдэхүүн

2.1. Редакцын зөвлөл нь Монгол Улсын хэмжээнд геологийн төрөл бүрийн зураг (геологийн, ашигт малтмалын, гидрогеологийн, геоморфологийн, геохимийн, геофизикийн, геоэкологийн, тектоникийн, тандан судалгааны гэх мэт) зохиох заавар (аргачлал), жишиг стандарт боловсруулж, хэрэглэх тухай зөвлөмжийг Үндэсний геологийн алба (цаашид ҮГА гэнэ)-нд бэлтгэн өгнө.

2.2. Редакцын зөвлөл нь 1.1-ийн дагуу геологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн үүднээс гүйцэтгэгч нарт зөвлөгөө өгөхөөс гадна зохиосон зургийн чанар, аливаа масштабын дагуу зураг зохиолтод хэрэглэдэг заавар, жишиг стандартын мөрдөлтөд редакц хийж, эцсийн үр дүнг зохиогчийн адил захиалагчийн өмнө хариуцна.

2.3. Редакцын зөвлөл нь ерөнхий редактор, зөвлөх, нарийн бичгийн дарга, мөн тухайн чиглэлээр мэргэшсэн салбарын эрдэмтэд, туршлагатай геологич, геофизикч, геохимич, гидрогеологич, техник арга зүйн мэргэжилтэн зэрэг гишүүдээс бүрдэнэ.

2.4. Редакцын зөвлөлийн бүрэн бүрэлдэхүүн ажиллах хугацаандаа Геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болох Үндэсний геологийн алба (цаашид ҮГА гэнэ)-тай мэдээлэл нууцлалын гэрээ байгуулах ба зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш гэрээнд хамаарах заалт 3 жил хүчинтэй үргэлжилнэ.

Гурав. Зөвлөлийн эрх үүрэг

3.1. Ерөнхий редактор нь дараах эрх, үүрэгтэй байна.

3.1.1. Редакцын зөвлөлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ.

3.1.2. Редакцын зөвлөлийг зарлан хуралдуулж, гишүүдийн саналыг үндэслэн шийдвэр гаргаж, гарсан шийдвэрийг ҮГА-нд танилцуулан, хэрэгжилтийг зохион байгуулна.

3.1.3. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн геологийн судалгааны ажлын үр дүнд Монгол Улсын хэмжээнд зохиогдсон геологийн төрөл бүрийн зураг, тайлбар бичигт редакц хийх гишүүдийг тухайн чиглэлийн зөвлөх нартай зөвшилцөн тухай бүр томилно.

3.1.4. Төслийн онцлогоос хамааран редакц хийх шаардлагагүй байж болох орон

нутгийн шинжтэй төслүүдийн хувьд ҮГА-тай зөвшилцөн шийдвэрлэнэ.

3.1.5. Редакцын зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдэд тухайн төсөлтэй холбогдсон тодорхой үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулна.

3.2. Редакцын зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрх, үүрэгтэй байна.

3.2.1. Редакцын зөвлөлийн гишүүний хувьд бусад гишүүдийн нэгэн адил ажиллахын зэрэгцээ удирдлага зохион байгуулалтыг хангахтай холбогдсон үндсэн үүргийг хүлээнэ.

3.2.2. 2.1-д заасан ажлын хүрээнд ерөнхий редакторын удирдлага дор, харин 2.2-т заасан ажлыг хэрэгжүүлэхэд гишүүдийг төсөл хэрэгжүүлэгчтэй холбон ажиллана.

3.2.3. Редакцын зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хуралдааны тэмдэглэл хөтөлж, гишүүдэд хуралдааны зар хүргэж, гишүүдийг хуралдаанд бүрэн оролцуулах арга хэмжээг авна. Редакцын зөвлөлийн хуралдаанд 70%-аас доош ирцтэй оролцсон гишүүдэд нэмэгдэл цалинг хувилан бууруулах хүртэл арга хэмжээг авах төслийг бэлдэж зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

3.2.4. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Редакцын зөвлөлийн хоорондын нягт хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна.

3.2.5. Гишүүний ёс зүйн асуудал эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар цаашид ажиллах боломжгүй болсон тохиолдолд зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс холбогдох гишүүнийг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, мэргэшлийн чиглэлийн дагуу түр хугацаагаар ерөнхий редактор нөхөн томилж, цаашид гишүүнээр ажиллуулах тохиолдолд ҮГА-нд уламжлан шийдвэрлүүлнэ.

3.3. Редакцын зөвлөлийн зөвлөх болон гишүүд нь дараах эрх, үүрэгтэй байна.

3.3.1. Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн судалгааны ажил гүйцэтгэж геологийн төрөл бүрийн зураг зохиох ажлын хүрээнд холбогдох заавар, жишиг стандартыг мөрдөхөд арга аргачлалын зөвлөгөө өгнө. Үүнд:

-ижил түвшний геологийн зураг, судалгааны ажлын үр дүнтэй харьцуулан холболт хийх, үүнтэй холбогдон гарсан маргаантай санал, зөвлөмжийг Редакцын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

-геологийн судалгааны төрөл бүрийн зураг чанарын өндөр түвшинд зохиох, холбогдох заавар, жишиг стандарт мөрдөх, дагалдах тайлбар бичгийг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэхэд нь гүйцэтгэгч нарт мэргэжлийн зөвлөмж өгнө.

3.3.2. Ижил төрлийн судалгааны ажлын хэмжээнд зураг хоорондын геологийн хил зааг болон бусад агуулгуудыг тохируулах үед зохиогчдын хооронд маргаантай асуудал тохиолдвол түүнийг шийдвэрлэх саналыг ҮГА-тай зөвшилцөн холбогдох захиалагчид хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

3.3.3 Редакц хийх явцад уг төслийн хэмжээнд хээрийн нэмэлт судалгаа явуулах, дээжлэлт, сорьцлолт зайлшгүй хийх шаардлага илэрсэн тохиолдолд Монголын Стартиграфийн комисс-д холбогдох мэдээллийг хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

3.3.4, Судалгааны ажлын үр дүнгийн геологийн төрөл бүрийн зургийн чанар хангалтгүй, улсын хэмжээгээр мөрдөгдөж буй заавар, жишиг стандартыг дагаж мөрдөөгүй нь тогтоогдвол түүнийг засах үүргийг зохиогч нарт өгөх ба хэрвээ эдгээр алдаа, зөрчил нь ноцтой бөгөөд гологдол гэж үзэхээр бол тухайн ажлыг зогсоох шаардлагыг Редакцын зөвлөлд тавьж ҮГА-аар шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Редакцын зөвлөлийн гишүүн нь тухайн төслийг хэрэгжүүлэхтэй ямар нэгэн байдлаар (зохиогч, шүүмжлэгч гэх зэргээр) сонирхлын зөрчил үүсэхээр бол уг ажилд редакц хийх эрхгүй бөгөөд сонирхлын зөрчилтэй тухайгаа ҮГА-нд мэдэгдэнэ.

4.2. Редакцын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын аргачлал, хяналтын дансанд төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Зөвлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн саналыг тухайн оны нэгдүгээр улиралд багтаан ҮГА-аар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан хэрэгжүүлнэ.

4.3. Үйл ажиллагааны зардалд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн нэмэгдэл цалин, шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод хамтын ажиллагаанд хамаарах зардал орно.

4.4. Нэмэгдэл цалинг Засгийн газраас тогтоосон төрийн захиргааны болон шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээнд мөрдөж байгаа албан тушаалын зэрэглэл, цалингийн сүлжээний шатлалтай харгалзах үндсэн цалингаас ерөнхий редактор, гишүүдэд 25 хувь, нарийн бичгийн даргад 30 хувиар тооцож НДШ, ХАОАТ-ийг хасаж олгоно. Энэ нь бүрэлдэхүүний ажилласан цаг, үйл ажиллагааны оролцоотой шууд уялдана.

4.5. Редакцын зөвлөлийн үйл ажиллагааны тайлан (санхүүгийн тайлангийн хамт)-г ҮГА-нд хагас болон бүтэн жилээр жилд нийт 2 удаа тайлагнана.